# ОРХОН АЙМГИЙН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХОЛБОГДОХ ЗААЛТУУДЫН ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ

2024.06.20 Эрдэнэт хот

| д/д | Хууль тогтоомж, үндэсний хөтөлбөрт тусгагдсан зорилт, үйл ажиллагаа | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Гүйцэтгэлийн үзүүлэлт | Хугацаа | Хэрэгжүүлэх байгууллага | Хэрэгжилтийн тайлан |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 1.Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх | 1.1. АТГ-аас бэлтгэсэн шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлага, зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, инстаграм youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр байгууллагын албан хаагчид болон олон нийтэд хүргэх (АТГ-ын цахим хуудас www.iaac.mn , “АТГ- олон нийтийн төв”, “Авлигатай тэмцэх газар” пэйж хуудсуудаас мэдээллүүдийг авах ) | - Сурталчилгааны ажлыг төлөвлөн зохион байгуулсан байх<br>- Баримтжуулж, үр дүнг тооцож тайлагнасан байх (түгээсэн тоо, давтамж, хандалтын тоо) | Жилдээ | Аймгийн ЗДТГ (Хууль, эрх зүйн хэлтэс) Сумдын ЗДТГ, Төрийн байгууллагууд, төрийн болон орон нутгийн өмчит ААН | Байгууллагын фэйж хуудасны нүүр зургийг Авлигатай тэмцэх газраас бэлтгэн гаргасан “Нэгдье” аяны хуудсаар сольж байршуулсан. |
| | | 1.2.Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар ажиллуулах ( албан ёсны цахим хуудас болон мэдээллийн самбараар) | -Самбарыг ажиллуулж мэдээллийг сар бүр шинэчлэх<br>-Тайланд энэ талаарх мэдээлэл, холбогдох баримтыг хавсаргасан байх | Жилдээ | Аймгийн ЗДТГ (Хууль, эрх зүйн хэлтэс) Сумдын ЗДТГ, Төрийн байгууллагууд, төрийн болон орон нутгийн өмчит ААН | Байгууллагын албаны ёсны фэйж хуудсаар Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн мэдээ, мэдээллийг нийтлэн хүргэж байна. Мэдээллийн самбарыг нээн ажиллуулах бэлтгэлийг хангаж байна. |
| | | 1.3.Авлигын эрсдлээс ангид байхад чиглэсэн ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий сурталчилгааг (шторк, зурагт хуудас, сонины нийтлэл, радио контент, цахим хэвлэмэл ном, гарын авлага, | -2-оос доошгүй сурталчилгааны материал боловсруулсан байх<br>-Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны | Жилдээ | Аймгийн ЗДТГ (Хууль, эрх зүйн хэлтэс) Сумдын ЗДТГ, | Байгууллагын мэдээллийн самбарт “Авлигын эсрэг нэгдье-110” гэсэн зурагт хуудсыг хэвлэн байршуулсан. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | брошюр, бусад арга хэлбэрээр) орон нутаг, байгууллагын хэмжээнд бэлтгэн явуулж сурталчилах | цахим хуудас болон нийгмийн сүлжээ, самбар зэрэг бүхий боломжит хэлбэрээр олон нийтэд хүргэсэн байх<br>-Авлигыг мэдээлэх 110 дугаарыг оруулсан байх<br>-Хамрагдсан албан хаагч, иргэдийн тоо | | Төрийн байгууллагууд, төрийн болон орон нутгийн өмчит ААН | |
| 2 | 2. Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, сургалтад хамруулах | 2.1.Албан хаагчдын авлигын эсрэг сургалт болон давтан сургалт, ёс зүйн сургалтад хамруулах | -Албан хаагчдыг сургалтад бүрэн хамруулсан байх<br>-Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо | Жилдээ | Сумдын ЗДТГ Төрийн байгууллагууд, төрийн болон орон нутгийн өмчит ААН, ХЭЗХ | 2023 оны ХАСХОМ гаргах болон байгууллагын нийт албан хаагчдад авлига ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх мэдлэг олгох сургалтыг аймгийн ЗДТГ-тай хамтран зохион байгуулж, нийт албан хаагчдын 90.4 хувь буюу 19 албан хаагчийг хамруулав. Үр дүнд ХАСХОМ гаргах арга зүйд суралцан эхний хагас жилд нийт албан хаагчид ашиг сонирхлын зөрчилгүй ажилласан. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль батлагдсантай холбогдуулан байгууллагынхаа албан хаагчдад ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ажлын байрны зөөлөн ур чадвар ба байгууллагын соёлын чиглэлээр соён гэгээрүүлэх сургалтыг 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр Улаанбаатар хотын Байгууллагын сургалтын лаб төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулсан. Сургалтад нийт албан хаагчдын 90.4 хувь буюу 19 албан хаагчийг хамруулан байгууллагын соёлын үндсэн |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ойлголт, орчин цагийн чиг хандлага, оролцогч талуудын эрх үүрэг, оновчтой удирдах, хэрхэн оролцох болон байгууллагын соёлд ажлын байрны зөөлөн ур чадварын хамаарлын талаарх онолын мэдлэгийг олгосноор төрийн албан хаагчтай холбоотой ёс зүй, харилцаа хандлагын зөрчил гараагүй. |
| | | 2.3.Тухайн байгууллагын хариуцдаг, шууд хамаардаг, хамтран ажилладаг ( тухайлбал тусгай зөвшөөрөл эзэмшигч, итгэмжлэгдсэн төлөөлөгч, хамтран ажилладаг бизнесийн байгууллага, хуулийн этгээд, иргэн, хяналт оролцоо хэрэгжүүлдэг ТББ г.м) байгууллагад авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах, ёс зүйг дээшлүүлэх, үйл ажиллагааны хүнд суртлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, түүний үр дүнг мэдээлэх, сурталчлах арга хэмжээг зохион байгуулах | -Өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан зохион байгуулсан байх<br><br>-Тайлагнасан байх | Жилдээ | Сумдын ЗДТГ Төрийн байгууллагууд, төрийн болон орон нутгийн өмчит ААН | Тайлант хугацаанд хүнс, хөдөө аж ахуйн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан 6 аж ахуйн нэгжийн зээлийн үр дүнгийн хэрэгжилтэд хяналт хийж, Авлигатай тэмцэх газраас хэрэгжүүлж буй "Нэгдье" аяны талаар товч танилцуулж, зурагт хуудсыг хэвлэн тарааж, сурталчилсан. |
| 3 | 3.Авлигын эрсдлийг бууруулах, авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан нөхцлийг арилгах арга хэмжээ авч ажиллах | 3.1.Авлигын эрсдэл ба авлига гаргах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх /үйлчилгээг цахимжуулах, хүнд суртлыг арилгах, шат дамжлагыг бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, эрсдлийн үнэлгээ хийлгэх г.м/ | -Эрсдлийг тодорхойлж, үр дүнтэй арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлсэн байх<br>-үйлчилгээг цахимжуулах, сайжруулах арга хэмжээг авч ажилласан байх<br>-цахим үйлчилгээний тоо | Жилдээ | Аймаг, сумдын ЗДТГ /бүх хэлтэс, тасгууд/ Төрийн байгууллагууд, төрийн болон орон нутгийн өмчит ААН | 2023 онд Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газраас төрийн зарим төрлийн үйлчилгээг орон нутгийн онцлогт тохируулан E-Mongolia системд оруулсантай холбогдуулан:<br>- Ноос, арьс ширний урамшуулал,<br>- Малчны тамга олгох,<br>- Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд олгох тодорхойлолт зэргийг e-mongolia системд байршуулсан тул e-mongolia.mn-ээс цахимаар үйлчилгээ авах боломжийг бүрдүүлсэн. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | 3.1.Шинээр томилогдсон нийтийн албан тушаалтнуудын томилогдсон шийдвэрт /захирамж, тушаал /хуульд заасан хугацаанд Хөрөнгө орлогын мэдүүлгийг мэдүүлж байх, ашиг сонирхлын зөрчил үүссэн болон ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл бий болсон нөхцөлд хуульд заасан мэдэгдэл тайлбарыг тухай бүрт нь гаргаж байх, авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах талаар холбогдох заалтыг тусгах | -Тушаалд холбогдох заалтыг оруулж үүрэгжүүлсэн байх | Жилдээ | Аймаг, сумдын ЗДТГ (ТЗУХ) Төрийн байгууллагууд, төрийн болон орон нутгийн өмчит ААН | Тайлант хугацаанд төрийн захиргааны ТЗ-9 ангилалын 1 албан хаагч томилогдсон бөгөөд ХАСХОМэдүүлэг гаргаагүй. Харин ашиг сонирхлын зөрчил үүссэн болон ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл бий болсон нөхцөлд хуульд заасан мэдэгдэл тайлбарыг тухай бүрт нь гаргаж байх, авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах талаар тухайн жилийн төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллах талаар арга зүйн зөвлөмж өгч, хэрэгжүүлэн ажиллаж байна. |
| 4 | 4.Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх | 4.1.Авлигын эсрэг үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, тогтоосон хугацаанд тайлагнах үр дүнг албан хаагчдад болон олон нийтэд мэдээлэх | -Төлөвлөгөөний хэрэгжилтийг тогтоосон хугацаанд хүргүүлсэн байх<br>-Удирдлагын зүгээс төлөвлөгөө болон төлөвлөгөөний хэрэгжилтийн явцыг хагас, бүтэн жилээр нийт албан хаагчдад танилцуулсан байх<br>-Олон нийтэд мэдээлсэн байх /цахим болон самбараар/<br>-албан хаагчдаас гаргасан санал, санаачилгыг хэлэлцсэн, хэрэгжүүлсэн байх | Жилдээ хагас, бүтэн жилээр | Аймгийн ЗДТГ (Хууль, эрх зүйн хэлтэс) Сумдын ЗДТГ, Төрийн байгууллагууд, төрийн болон орон нутгийн өмчит ААН | Төлөвлөгөөний холбогдох заалтын хэрэгжилтийн тайланг тогтсон хугацаанд гарган ажиллаж байна. Төлөвлөгөө болон төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг байгууллагын мэдээллийн самбарт нийтлэн албан хаагчид, хэрэглэгч мэдээллээр хангагдах нөхцлийг бүрдүүлсэн. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 5 | 5.Байгууллагын үйл ажиллагааны ил тод нээлттэй байдлыг сайжруулах | 5.1. Төрийн байгууллага бүр албан ёсны цахим хуудастай /сайт/ байх, сайтын үйл ажиллагааг идэвхжүүлэх, шинэчлэх, сайжруулах ажлыг тогтмол зохион байгуулах | -Цахим хуудасны дизайн загварыг иргэд мэдээллийг шуурхай, ойлгомжтой байдлаар олж авах боломжтой байдлаар өөрчилж шинэчилсэн байх<br>-төрийн байгууллагууд харьяа салбар байгууллагуудын ил тод байдалд хяналт тавих, цахим хуудастай болгох ажлыг зохион байгуулж ажилласан байх | Жилдээ байнга | Аймгийн ЗДТГ (ТЗУХ) Сумдын ЗДТГ, Төрийн байгууллагууд, төрийн болон орон нутгийн өмчит ААН | Байгууллагын ил тод байдлыг хангах үүднээс байгууллагын пэйж хуудас, мэдээллийн 2 самбар, байгууллагын коридорт байршуулсан 42 инчийн зурагтаар мэдээ, мэдээллийг нийтэд хүргэж байна. |
| | | 5.2.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах | - Цахим хуудаст хуульд заасан нээлттэй мэдээллийг байршуулах чиг үүргийг холбогдох ажилтнуудад хариуцуулж, шийдвэр гаргаж баталгаажуулсан байх<br>- хуульд заасан нээлттэй мэдээллүүдийг бүрэн байршуулсан, мэдээллийг шинэчилсэн байх | Жилдээ | Аймгийн ЗДТГ (Хууль, эрх зүйн хэлтэс, Төрийн захиргааны удирдлагын хэлтэс) Сумдын ЗДТГ Төрийн байгууллагууд, төрийн болон орон нутгийн өмчит ААН | Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын тушаалаар байгууллагын үйл ажиллагааг ил тод нээлттэй мэдээлэх, мэдээлэл оруулах, цахим хуудасны хэвийн тасралтгүй үйл ажиллагааг ханган ажиллах ажлыг хариуцах 8 албан хаагчийг томилсон. Салбарт мөрдөгдөж байгаа хууль, тогтоомж, дүрэм, журам, заавар, төрийн мэдээллийг аймгийн мэдээллийг Erdenet.mn сайт, "Орхон аймаг. Хүнс, хөдөө аж ахуйн газар" пейж хуудас, байгууллагын мэдээллийн самбарт тухай бүр байршуулан иргэд, аж ахуйн нэгж, олон нийтэд мэдээлэн ажиллаж, 48 мэдээлэл байршуулснаас 4200 хүн хандсан байна. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | 6.3.Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хуулийн хэрэгжилтийн байдалд хяналт шалгалтыг зохион байгуулж, шаардлагатай арга хэмжээг авах | - Мэдээллийг бүрэн байршуулсан байх<br>- Хяналт шалгалтыг зохион байгуулж, арга хэмжээг авсан байх | Жилдээ хуульд заасан хугацаанд | Аймгийн ЗДТГ ( Санхүү, төрийн сангийн хэлтэс), Санхүүгийн хяналт аудитын алба, Сумдын ЗДТГ Төрийн байгууллагууд, төрийн болон орон нутгийн өмчит ААН | Хүнс хөдөө аж ахуйн газрын даргын 2024 оны "Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах тухай" А/01 дүгээр тушаалаар https://gap.mof.gov.mn/ системийн мэдээлэл оруулах хэрэглэгчээр Захиргаа, аж ахуйн албаны дарга, Ж.Баярмандах, ахлах нягтлан бодогч О.Оюун-Эрдэнэ нарыг томилгоожуулсан. Аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн оруулж, байгууллагын ил тод байдлыг хангаж ажилласан. |
| | | 6.4. Ил тод байдлыг хангах, шинээр батлагдсан Мэдээллийн ил тод байдлын тухай хууль болон 2023 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт шинжилгээ үнэлгээний дагуу өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллах | -Зөвлөмжийн дагуу төлөвлөгөө гаргаж ажиллаж, хэрэгжилтийг 11 сард тайлагнасан байх | Жилдээ | ХХААГазар, Бүх албадууд | Аймгийн Засаг даргын тамгын газрын хяналт, шинжилгээ, үнэлгээний хэлтсээс ХХААГазрын 2023 оны байгууллагын үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын зөвлөмжийн хэрэгжилтийг 11 сард тайлагнаж ажиллах тул төлөвлөгөө боловсруулж байна. |

ТАНИЛЦСАН:

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ДАРГА Ж.БАТ-ӨЛЗИЙ

ХЯНАСАН:

ХХААГ-ЫН ЗАХИРГАА, АЖ АХУЙН АЛБАНЫ ДАРГА Ж.БАЯРМАНДАХ

БИЕЛЭЛТ НЭГТГЭСЭН:

ХХААГ-ЫН ХҮНС, ХООЛ ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АСУУДАЛ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Ц.ГАНХУЯГ